

**МАНДАЛ ДААТГАЛ ХК-НИЙ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дугаар зүйл, Мандал даатгал хувьцаат компанийн дүрмийн 8.14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Мандал даатгал ХК нь 2021 онд ашигтай ажилласныг үндэслэн 2021 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 3 /гурван/ төгрөг буюу нийт 1,872,904,800.00 /нэг тэрбум найман зуун далан хоёр сая есөн зуун дөрвөн мянган найман зуун/ төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгохоор тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын дагуу хуваарилах ногдол ашгийг 2022 оны 05 сарын 31-ны өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар олгосугай.
4. Энэхүү тогтоолын дагуу ногдол ашиг хуваарилсны дараа Компани нь төлбөрийн чадвартай байх бөгөөд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа болохыг дурдсугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах ажлыг гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ч.Даваадашид даалгасугай.

Энэхүү шийдвэрийг 2022 оны 02-р сарын 18-ны өдөр бичгээр үйлдсэнийг гэрчлэн Компанийн тухай хуулийн 80.2 болон Компанийн дүрмийн 8.16-г тус тус үндэслэн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ